



МОНГОЛ УЛС
ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2022 оны 03 сарын 24 өдөр

Дугаар А/162

Ховд

Хөрөнгө гаргах тухай

Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, 41 дүгээр зүйлийн 41.2.2 дахь заалт, Сангийн сайдын 2018 оны 318 дугаар тушаалаар баталсан Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журмын 2.1.6 дахь заалт, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2017 оны 28 дугаар тогтоолоор баталсан “Аймгийн шагналын журам”-ын 1.2.9, 3.3.3 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Сум, орон нутгийн хөгжил цэцэглэлт, бүтээн байгуулалт, эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үйлсэд өөрийн сэтгэл зүрх, эрдэм мэдлэгээ дайчлан мал эмнэлгийн салбарт олон жил үр бүтээлтэй ажиллаж буй Цэцэг сумын мал эмнэлгийн тасгийн тархвар зүйч Жалцавын Гансүх, Дуут сумын малын эмч Батнасангийн Мөнхбат, Дөргөн сумын малын эмч Санжсүрэнгийн Чимэд нарыг аймгийн Засаг даргын Хүндэт өргөмжлөлөөр шагнахад 90,000 төгрөг (ерөн мянга)-ийг зарцуулсугай.

2. Дээрх арга хэмжээнд зарцуулах 90,000 төгрөг (ерөн мянга)-ийг Засаг даргын нөөц хөрөнгөөс гаргахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга (Д.Энхболд)-д зөвшөөрсүгэй.

3. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга (Ч.Багдал)-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА

Б. ДҮГЭРЖАВ

